Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

# Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А. Д. Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

22 дахь жилдээ № 82 (1866) | 1969 оны 10 дугаар сарын 31 | БААСАН

## АЙМГИЙН НАМЫН ХОРООНЫ ТОВЧООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

1969—10—23 № 322 Зуунмод хот

*Аймгийн Намын Хорооны V бүгд хурлыг хуралдуулах тухай*

*Аймгийн Намын Хорооны Товчооны хурлаас ТОГТООХ нь:*

*1. Аймгийн Намын Хорооны V бүгд хурлыг 1969 оны 12 дугаар сарын 2 дугаар хагаст хуралдуулсугай.*

*2. Аймгийн Намын Хорооны V бүгд хурлаар ХАА—д тэргүүн туршлага нэвтрүүлэхэд намын байгууллагуудын зорилтын тухай хэлэлцүүлсүгэй.*

*3. Аймгийн Намын бүгд хурлыг 1969 оны улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг үзүүлэлт бүрээр нь тоо чанарын талаар биелүүлсэн өрнүүн амжилтаар угтахыг аймгийн нам, улс, олон нийт, аж ахуй, соёлын байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.*

Аймгийн Намын Хороо

## АХМАД ТЭЭВЭРЧДЭЭС СУРАЛЦАЯ

Аймгийн ачаа тээврийн дийлэнхийг авто машинаар гүйцэтгэж байна.

Одоо үед авто машин чиргүүлийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх асуудал чухал зорилтын нэг болж байгаа бөгөөд түүнд шаардагдах засвар техникийн үйлчилгээ, материал техникийн хангамжийг сайжруулж мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх талаар нам засгаас онц анхаарал тавьж байна.

Аймгийн намын IV бүгд хурлын шийдвэрийг биелүүлж авто машин, түүний чиргүүлийг үр ашигтай удаан хугацаагаар осол зөрчилгүй эзэмшиж байгаа ахмад тээвэрчдийн баялаг туршлагаас залуу тээвэрчдэд эзэмшүүлэх, авто машин чиргүүлийг ашиглах талаар авто тээврийн 13 дугаар бааз, Жаргалантын САА зэрэг албан байгууллага амжилттай ажиллаж байна.

МАХН—ын Төв Хорооны V бүгд хурлаас тээврийн хэрэгслийн ашиглалт, түүний материал техникийн хангамж, нийгмийн үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх талаар тодорхой заалт гарсан билээ.

Энэхүү заалтыг биелүүлэхийн тулд тээвэрлэлтийн өөрийн өртгийг хямдруулах, авто машины засвар техникийн үйлчилгээ, засварын чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх нь чухал байна.

Засварын чанарыг сайжруулах нь нийгмийн хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх эдийн засгийн өндөр үр ашиг бүхий хөшүүрэг мөн.

Аймгийн тэргүүний тээвэрчдийн анхдугаар зөвлөлгөөнийг угтаж авто аж ахуй бүхий албан үйлдвэрийн газрууд, авто машины чиргүүлийн ашиглалтыг сайжруулах, тээвэрчдийн мэргэжил боловсролын хэмжээг дээшлүүлэх, авто паркийн бүтэц, өвлийн бэлтгэлийг бүрэн хангасан байх хэрэгтэй.

Мөн авто аж ахуй бүхий газрууд тэргүүний ажиллагаатай ахмад тээвэрчдийнхээ туршлагыг сурталчлах өргөн далайцтай ажил зохиох нь чухал юм.

Тээврийн үйлдвэрлэлийг явуулж байгаа авто аж ахуйнуудад он удаан жил осол зөрчилгүй үр бүтээлтэй ажиллаж байгаа ахмад тээвэрчдийн туршлагыг залуу тээвэрчдэд эзэмшүүлэх нь нийтийн хэрэгцээний ачаа тээврийн бааз болон авто аж ахуй бүхий албан үйлдвэрийн газруудын хойшлуулшгүй зорилт байх ёстой. Тээвэрчдийн зөвлөлгөөнийг угтаж, тээвэрчин бүр сар, улирал, жилийн норм төлөвлөгөөг биелүүлэхийн тулд тодорхой зорилт тавин ажиллах явдал чухал байна.

## Ухуулагчдын бүсийн зөвлөлгөөн

Саяхан аймгийн бүх ухуулагчдын бүсчилсэн зөвлөлгөөн Борнуур, Заамар, Баяндэлгэр, Баянжаргалан, Гачуурт, Өнжүүл, Өндөрширээт, Их хайрхан зэрэг 8 газарт явагдаж өнгөрөв. Бүсийн зөвлөлгөөнд аймгийн Намын Хорооны үзэл суртлын хэлтсээс «В.И. Ленин ба БНМАУ», «Их ойнууд угтсан, намын ухуулга ба ухуулагчдын зорилт» гэсэн илтгэл тавьж хэлэлцүүлэв.

Зөвлөлгөөнд 300-гаад ухуулагчид оролцож, 77 ухуулагч өөрсдийн туршлагыг ярив. Бүсийн зөвлөлгөөний үзэсгэлэнд 1450 гаруй үзүүлэн, 51 ухуулагчийн тэргүүн туршлага тавигдсан байна. Мөн 58 цагийн семинар явагдаж, концерт, кино, үдэшлэг олон удаа зохиогджээ. Ухуулагчдын бүсийн зөвлөлгөөн, намын үзэл суртлын ажлыг улам тодорхой болгож, үйлдвэрлэл—амьдралтай холбоход чухал алхам боллоо.

П. Очирбат

Нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойд

## БАРИЛГАЧИН САНЗАА

Санзаа гуай сайн барилгачин, дархан, мужаан гэдгээрээ сумандаа алдаршсан хүн.

Тэрээр Улаанбаатар хотын барилгын артелийн ангиас өөрийн хүслээр 1966 онд ирж ажилласнаасаа хойш том жижиг 60 шахам барилга барьж засварлан ашиглалтанд өгчээ. 1969 онд бригад, сумын төвд нийтдээ 10 шахам барилганд засвар хийгээд одоо 4 айлын орон сууц барьж байна.

Мөн бригадынхаа 4 хүнтэй хамтран богийн хашаа нэгийг барьжээ.

Санзаа гуай ярихдаа:
Би улсад 41 жил ажиллаж байна.

Үүнийхээ 19 жилийг барилгын ажилд зориуллаа. Би барилгын ажлаас 2—3 төрлийн шинэ мэргэжил олж авсан хүндээ.

Үүндээ их баярлаж явдаг. Бид нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойдоо зориулан барьж байгаа 4 айлын сууцаа дуусгахаар чармайн ажиллаж байна гэж Лүн сумын «Энхтуул» нэгдлийн барилгачин Санзаа ярив.

Б. Цэдэн

## ЗҮТГЭЛТЭЙ СУВИЛАГЧ

Жаргалантын САА дахь сум дундын эмнэлгийн сувилагч Долгорцэнд 1955 оноос эхлэн сувилагчаар ажиллажээ.

н. Долгорцэнд мэргэжил мэдлэгээ дээшлүүлэхийн тулд байнга анхаарч ажилладгийн дээр өвчтөнд эхийн сайхан сэтгэлээр хандан сувилдаг, даруу төлөв зантай ажилч хичээнгүй хүн юм.

Түүнчлэн эмнэлэг гэгээрлийн суртал нэвтрүүлгийн ажилд идэвхтэй оролцон, больницын өвчтөнд элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга тогтмол зохиож, олон түмнийхээ хайр талархлыг хүлээсээр явна.

С. Цэрэндорж

## *Найрамдлын сараар*

Төвийн 10 жилийн дунд сургууль пионерийн бүлгэм Монгол—Зөвлөлтийн найрамдлын сараар пионер сурагчдын дунд зөвлөлтийн хүүхдийн зохиолч Маршак, Носов, Чуковский нарын зохиолоор багт наадам явуулж «Зөвлөлтийн хүүхдийн утга зохиол», «Зөвлөлтийн хүүхдийн гоо зүй» гэсэн сэдвээр лекц уншиж, В. И. Лениний нэрэмжит найрал, гоцлол дууны 10 хоног зохиов.

Мөн зөвлөлтийн кино 7 хоног зохион явуулж «Октябрийн социалист их хувьсгал» гэсэн сурлагын 14 хоногийн цуваа зарлан ажиллуулж байна.

Сурагч Лайжинханд

## ДӨРӨВДЭХ УДААГАА ТҮРҮҮЛЭВ

Борнуур сумын Харилцаа Холбооны салбар, (эрхлэгч нь Дариймаа) өөрийн байгууллагын үйлчилгээг хөнгөн шуурхай болгон ажилласны үр дүнд сумын төвийн албан байгууллагуудын хоорондын социалист уралдаанд дөрөвдэх удаагаа түрүүлж социалист уралдаанд шилжин явах туг, баярын бичиг, үнэ бүхий зүйлээр шагнагдав.

Д. Дашцэрэн

*Найрамдлын сард*

## МАНАЙ АЙМАГТ

БНМАУ—ын Засгийн газрын урилгаар манай оронд зочилж байгаа ЗХУ—ын маршил В. И. Чуйков тэргүүтэй зөвлөлтийн цэргийн төлөөлөгчдийн зарим гишүүд Зуунмод хотын нилээд албан байгууллага, орон нутгийг судлах музейг үзэж сонирхов.

Зочид Сэргэлэн сумын «Авдархангай» нэгдлийн хоёрдугаар бригадын гишүүн Батсүхийн сууриар зочилж нэгдэлчдийн ажил амьдралтай танилцлаа.

БНМАУ—ын Батлан хамгаалах яамны орлогч сайд, дэслэгч генераль С. Равдан, Ардын цэргийн улс төрийн газрын дарга, хошууч генераль Д. Ёндондүйчир, Аймгийн Намын Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ш. Агваансодов, АДХГ Захиргааны дарга Ц. Жамсран нар зочдын хамт явлаа.

* * *

Монгол—Зөвлөлтийн найрамдлын сарыг тохиолдуулан ЗСБНХУ—аас БНМАУ—д суугаа элчин сайдын яамны ажилтан В. Д. Доргунов Зуунмод хотын намын гишүүд болон хариуцлагатнуудад «Октябрийн социалист их хувьсгалын 52 жилийн ой» гэсэн лекц уншив.

Манай сурвалжлагч

## *НАМЫН ГИШҮҮД МАНЛАЙЛЖ БАЙНА*

Алтанбулаг сумын Алтанбулаг бригадын намын гишүүн Чинбат ахлагчтай үнээн суурийнхан 1969 онд тушаах 64000 литр сүүгээ 101 хувиар биелүүлсний дотор намын гишүүн Чинбат 151 хувь, намын гишүүн Оросоо 101 хувь, Должин нарын бусад саальчид 100 хувиар биелүүлжээ. Чинбат, Оросоо нар тус сумын анхны 600 мянгач саальчид бөгөөд сүүлийн 5 жил дараалан сүүний үйлдвэрлэлийн даалгавраа биелүүлж байна. Энэ хоёр саальчин өөрсдийнхөө ажлын аргаа бусдад хэлж өгөхийн хамт сууртаа бичиг үсгийн бүлгэм тогтмол ажиллуулж, саальчдын ажлын дүнг 7, 10, 15 хоногоор гаргах зэргээр хамт олондоо нөлөөтэй ажиллаж нэгдэлжих хөдөлгөөн ялсны 10 жилийн ойгоо угтаж, намын гишүүний манлайллаа биелүүлж байна.

Ш. Динам

